

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**2023 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

	Үүрэг даалгаврын дагуу хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг даалгавар НЭГ: Нийслэлийн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг сайтар хангаж, өвлийн их ачааллын үед иргэдийг ус, дулаан, цахилгаан эрчим хүчээр найдвартай хангахад онцгой анхаарах, инженер хангамжийн байгууллагуудыг энэ сарын 15-ны дотор ажлуудаа бүрэн дуусгах, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай бригадыг бэлэн байлгах. /Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар, Инженер хангамжийн байгууллагууд/				
1	Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/817 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2023 оны А/236 дугаар захирамжаар 45 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулсан. Дүүргийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн ээлжит хуралдаан болон Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаануудад Чингэлтэй дүүргийн хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц болон тулгамдаж байгаа асуудлаар мэдээлэл танилцуулсан. Үүний дагуу өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлыг эрчимжүүлж, сар бүрийн 20-ны өдрийн дотор дэлгэрэнгүй тайлан, мэдээг авч, удирдлагуудын шуурхай хурлаар танилцуулж ажиллах талаар чиглэл өгөн ажиллалаа. ОСНААУГ-ын ХҮТ-6, 7, “Ану сервис” ХХК, “Элбэг дулаан” ХХК-ууд инженер хангамжийн засварын ажлыг бүрэн хийж дуусгасан бөгөөд халаалт өгөх бэлтгэл ажлыг 100 хувь хангаж, бэлтгэл ажлыг хангасан.			70
Үүрэг даалгавар ХОЁР: Худалдаа үйлчилгээний байгууллагуудын барилгын гадна шат, довжоог хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах, нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт, цэвэрлэгээг тогтмолжуулах, явган хүний зам, гадна хаяг, рекламн самбар, бүрэн бүтэн байдал алдагдсан, эрсдэл үүссэн хүүхдийн тоглоомын талбайг засварлах, аюулгүй байдлыг хангуулж стандартад нийцүүлж ажлыг эрчимжүүлэх. /Захирагчийн ажлын алба, Дүүргийн Засаг дарга нар, Хотын стандарт, хяналтын газар/				
2	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/242, дүүргийн Засаг даргын 2023 оны А/120 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт зах, худалдааны төв чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 6 аж ахуйн нэгжид холбогдох хууль, тогтоомж, норм, дүрэм, стандартыг хангуулахаар Хүнс хөдөө аж ахуйн газар, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн			70

	<p>хэлтэс, дүүргийн Цагдаагийн газар, дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэстэй хамтарсан хяналт шалгалтыг 2023 оны 08 дугаар сарын 18,23-ны өдрүүдэд зохион байгуулсан.</p> <p>Тус хяналт, шалгалтаар зах, худалдааны төвүүдэд барилгын гадна шат, довжоо, авто машины зогсоолыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах, нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт, цэвэрлэгээг тогтмолжуулж хэрэгжилтийг ханган ажилласан талаарх тайланг 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлэх хугацаатай үүрэг өгч ажилласан.</p> <p>Нийтийн эзэмшлийн гудам зам талбайн цэвэрлэгээний ажлыг өдөр бүр тогтмол цэвэрлэн ажиллаж байгаа ба нийт 108 хүний бүрэлдэхүүнтэй зам талбайн үйлчлэгч 247 байршлын 793,357м2 талбайг цэвэрлэн ажиллаж байна.</p> <p>Мөн Улсын төсвийн хөрөнгөөр Тахилтын аманд 4 тэрбумаар тохижилтын ажил хийж гүйцэтгэхээр зураг төсвийг “Сийвэл дизайн” ХХК хийж гүйцэтгэн тендер зарлан гүйцэтгэгчээр Жавхлан хүслэн ХХК шалгарч газар шорооны ажил 80%, гэрэлтүүлгийн суурь шон тавигдсан, шат хийгдсэн, тоглоомын талбайн ажил хийгдэж байна. Нийт 10 бичил цэцэрлэгт засварын ажил хийж гүйцэтгэсэн ба 4 байршилд 3*3 сагсан бөмбөгийн талбай шинээр байгуулаад байна. 5 дугаар хороо 11, 12 дугаар байрны урд талын буулгасан 33 гарааш байршилд 640м2 талбайд Хот тохижилтын газраас авто зогсоол ногоон байгууламжийн ажлыг эхлүүлээд байна.</p> <p>Дүүргийн Засаг даргын А/78 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж нийтийн эзэмшлийн гудамж зам талбай рекламн байгууламжийн бүрэн бүтэн байдал нь алдагдсан зөвшөөрөлгүй самбар байрлуулсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад мэдэгдэх хуудас хүргүүлж Соёндрийм ХХК 45 самбарын буулгалт хийсэн байна.</p>			
<p>Үүрэг даалгавар ГУРАВ: Хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, биеийн тамир спортоор хичээллэх нөхцөл боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд 3*3 сагсан бөмбөгийн талбай байгуулах болон бусад тохижилтын ажлуудыг эрчимжүүлж ажиллах. Үүнд: /Бага тэнгэр, Драмын театр, Хүүхдийн парк, гэр хорооллын бичил, цэцэрлэг, гарааш буулгасан талбайг тохижуулах ажил/ Захирагчийн ажлын алба, Хөрөнгө оруулалтын газар Хот тохижилтын газар Дүүргийн Засаг дарга нар/</p>				
3	<p>Дүүргийн төсвийн хөрөнгөөр 12, 14, 17, 18, 19 дүгээр хороодын тоглоомын талбайнуудад засварын ажил хийгдэж дууссан. Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023 онд болон он дамжин 5, 8, 12, 13, 14, 16, 17, 18, 19 дүгээр хороодод нийт 1,3 тэрбум төгрөгөөр 12 бичил цэцэрлэгүүд, 3*3 сагсан бөмбөгийн талбайнуудад засвар шинэчлэлтийн ажил хийгдэж комисс ажиллаж ашиглалтад авсан. Дүүргийн 11 дүгээр хороо Нуурын 14, 15 дугаар гудамжинд 1000м2 явган зам, 541м2 асфальт гүйлтийн зам, 2143м2 бетонон явган зам тус тус хийж гүйцэтгээд байна.Улсын төсвийн хөрөнгөөр Тахилтын аманд 4 тэрбумаар тохижилтын ажил хийж гүйцэтгэхээр зураг төсвийг “Сийвэл дизайн” ХХК хийж гүйцэтгэн тендер зарлан гүйцэтгэгчээр Жавхлан</p>			70

	хүслэн ХХК шалгарч газар шорооны ажил 80%, гэрэлтүүлгийн суурь шон тавигдсан, шат хийгдсэн, тоглоомын талбайн ажил хийгдэж байна. Нийт 10 бичил цэцэрлэгт засварын ажил хийж гүйцэтгэсэн ба 4 байршилд 3*3 сагсан бөмбөгийн талбай шинээр байгуулаад байна. Дүүргийн 5 дугаар хороо 11, 12 дугаар байрны урд талын буулгасан 33 гараашны байршилд 640м2 талбайд Хот тохижилтын газраас авто зогсоол ногоон байгууламжийн ажлыг эхлүүлээд байна.			
Үүрэг даалгавар ДӨРӨВ: Хүүхдийн тоглоомын талбай, Сагсан бөмбөгийн талбай болон цэцэрлэгт хүрээлэнгийн орчимд 22:00 цагаас хойш иргэд, оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулж байгаатай холбогдуулан ирсэн зөрчлийн дуудлага мэдээлэл, шөнийн цагаар ирэх болсон шалтгаан нөхцөлийг судалж, түүнийг арилгах, чиглэлээр зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах. /Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Дүүрэг, хороодын Засаг дарга нар/				
4	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт шөнийн цагаар Хүүхдийн тоглоомын талбай болон сагсан бөмбөгийн талбай, цэцэрлэгт хүрээлэнгийн орчимд иргэд, оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулж байгаатай холбогдуулан зөрчлийг арилгах чиглэлээр дүүргийн Цагдаагийн газрын даргын тушаалаар цагдаагийн 1, 2 дугаар хэлтсийн нийт алба хаагчдыг долоо хоног бүрийн Баасан гарагийн 19:00-01:00 цагийн хооронд явган эргүүлийг ажиллуулж, давхардсан тоогоор нийт 4 удаа 88 чиглэлд 176 алба хаагч үүрэг гүйцэтгэж, оршин суугчдын амгалан тайван байдлыг ханган, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхааран ажиллаж байна. Мөн оройн цагаар Хүүхдийн тоглоомын талбай, Сагсан бөмбөгийн талбайд бүлэг бөөгнөрөл үүсгэж, оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулаад байгаа иргэдийг тараах, мөн гэмт хэрэг зөрчилд өртөж хохирч холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрт үүрэг гүйцэтгэж байгаа албаны авто машинууд чанга яригчаар сэрэмжлүүлэг, мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.</p> <p>Мөн шөнийн цагаар тоглоомын талбайд хүүхдүүд гэмт хэрэг зөрчилд өртөж хохирч, холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор Хүүхдийн тоглоомын талбай болон Сагсан бөмбөгийн талбайг 22:00 цагаас хойш ажиллуулахгүй байх талаар хамтран ажиллах тухай дүүргийн Цагдаагийн газрын даргын 2023 оны 28л-1/4369-4379 дугаарын албан бичгийг 1-24 дүгээр хороодын Засаг дарга нар болон Сууц өмчлөгчдийн холбооны захирлуудад хүргүүлж, хамтран ажиллаж байна.</p>			90
Үүрэг даалгавар ТАВ: Нийслэл дэх Төрийн аудитын байгууллагын аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг сайтар хангуулж, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналттай холбоотой холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөн, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй анхаарч ажиллах. /Нийт байгууллагууд/				
5	Нийслэл дэх Төрийн аудитын байгууллагын аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд дүүргийн хэмжээнд нийт төлөгдсөн Актын хэмжээ 72,2%, Зөвлөмжийн хэрэгжилт 80%-тай ажиллаж байна. Нягтлан бодох			90

	бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөн ажиллаж, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч, дүүргийн харьяа байгууллагуудын нягтлан бодогч нарт 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Мөн 2022 оны Чингэлтэй дүүргийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн албан шаардлагыг өмнөх оныхоос 10%-иар бууруулж ажиллалаа.			
Үүрэг даалгавар ЗУРГАА: Нийслэлийн Засаг даргын ажлын хэсэг байгуулсан захирамжуудын хэрэгжилтийг эрчимжүүлж, хяналт тавьж ажиллах. /Ажлын хэсгийн дарга нар/				
6	Нийслэлийн Засаг даргын ажлын хэсэг байгуулах тухай 2023 оны А/321, А/358, А/383, А/394, А/595, А/596 дугаар захирамжуудын хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа ба Нийслэлийн Засаг даргын ажлын хэсэг байгуулах тухай захирамжийн хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын ажлын хэсэг байгуулах захирамжийн дагуу дүүргийн хэмжээнд ажиллаж байгаа ажлын хэсгийн дарга нарт 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн нийслэлийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн дээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн үүрэг даалгаврыг танилцуулж, хэрэгжилтийг эрчимжүүлж, хяналт тавин ажиллах талаар үүрэг чиглэл өгч ажиллалаа.			90
Үүрэг даалгавар ДОЛОО: Нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын хариуцлагыг сайжруулж, байгууллагуудаас ирүүлж байгаа тайлан мэдээний чанарт ахиц гаргах, хэрэгжилтийг үнэн, зөв, шуурхай тайлагнаж, бодит мэдээллээр хангаж ажиллах. /Нийт байгууллагууд/				
7	Нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны А/242 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороог байгуулж, 2 удаагийн хурлаар 3 албан хаагчийн асуудлыг хэлэлцсэн. Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийг сурталчлах, албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр дүүргийн Засаг даргын Тамгын газраас шинээр батлагдсан хуулийн талаар нийт ажилтан, албан хаагчдад 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ёс зүй, өргөдлийн хорооноос “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр тус тус сургалт зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн дүүргийн Засаг даргын эрхлэх хүрээний харьяа нийт байгууллагуудад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг албан хаагчдадаа танилцуулж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 3/2065, 3/2066, 3/2067 дугаарын албан бичгээр чиглэл хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс албадын үйл ажиллагааны тайлан, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, холбогдох тайлан, биелэлтийг хуулийн			90

хугацаанд нэгтгэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэж, холбогдох дээд байгууллагуудад хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна.			
---	--	--	--

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА П.БАЯНБААТАР

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Л.БАЯРМАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Э.ХУЛАН

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Д.БЯМБАСҮРЭН